



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2019 оны 05 сарын 13 өдөр

Дугаар A/96

Ховд

**Үнэлгээний хороо байгуулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Жаргалант сумын Цамбагарав багт баригдах Жаргалант агро парк, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Жаргалант сумын Буянт, Раашаант, Баатархайрхан багуудын нийтийн байрны дээвэр, фасад, орцны засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга:	Ш.Нохойжав	-Орон нутгийн өмчийн газрын дарга
Гишүүд:	Н.Эрдэнэцэцэг	-Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн
		- Төрийн бус байгууллагын төлөөлөл
	Б.Дэлгэрмаа	- Иргэн
	Ц.Баяржаргал	

Нарийн бичгийн дарга:

X.Дэмид	- Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа харилцаа хариуцсан мэргэжилтэн
---------	--

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Ш.Нохойжав/-нд даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга / X.Дэмид/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ЭНХБОЛД

02 00422  
D/Tush-A/96-Da